

БАТЛАВ
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРДОН ГҮЙЦЭТГЭГЧ

И.БААТАРХҮҮ

2023 оны 09 дүгээр сарын 28

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН АЛБАН ХААГЧДЫН
ДУНД ЗОХИОН БАЙГУУЛАХ "МЭДЬЕ, НЭГДЬЕ" АЯНЫ
УДИРДАМЖ

Нэг. Зорилго

Нийслэл хот үүсэн байгуулагдсаны 384 жилийн ойг угтан Монгол Улсын Засгийн газраас Авлигатай тэмцэх жилийн хүрээнд хэрэгжүүлж буй "5 Ш ажиллагаа", Авлигаас урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын ёс зүй, авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх, багаар ажиллах чадварыг сайжруулах, байгууллагын үйл ажиллагааны чадавхыг дээшлүүлэхэд энэхүү аяны зорилго оршино.

Хоёр. Аяны хугацаа, хамрах хүрээ

2.1. Аяныг 2023 оны 10 дугаар сарын 02-ны өдрөөс 10 дугаар сарын 25-ны өдөр хүртэлх хугацаанд зохион байгуулна.

2.2. Аянд Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын хэлтэс, нэгжүүд хамрагдана.

Гурав. Хэрэгжүүлэх арга хэмжээ

I. Аяны хүрээнд дараах арга хэмжээнүүдийг зохион байгуулна. Үүнд:

3.1. "Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль", "Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам"-ын талаар сургалт зохион байгуулна.

3.2. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Ёс зүйн дэд хороог албан хаагчдын саналаар шинэчлэн байгуулна.

3.3. Авлигатай тэмцэх газраас зохион байгуулж буй НЭГДЬЕ аяныг дэмжин Авлигын эрсдэлээс ангид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий (шторк, зурагт хуудас, сонины нийтлэл, радио контент, цахим, хэвлэмэл ном, гарын авлага, брошур зэргээс боломжит хэлбэрийг сонгон) сурталчилгааг хийж олон нийтэд хүргэнэ.

3.4. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын авлигаас урьдчилан сэргийлэх, ил тод байдлыг сайжруулах, ёс зүйг дээшлүүлэх, хүнд суртлыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, түүний үр дүнг мэдээлж, сурталчилна.

3.5. Иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн хариутай албан бичиг, өргөдөл, гомдлыг холбогдох хууль, журмын хүрээнд бүрэн дүүрэн шийдвэрлэж, иргэдэд төрийн үйлчилгээг хүнд сурталгүй, мэргэжлийн түвшинд гүйцэтгэх чиглэлээр нөлөөллийн арга хэмжээг авна.

3.6. Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвөөр үйлчлүүлэгчдээс авлигын эрсдэл, үйл ажиллагааны хүндрэл бэрхшээлийг тодорхойлох сэтгэл ханамжийн судалгаа авна.

3.7. Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвийн албан хаагчдын үзүүлж буй үйлчилгээний чанар, хүртээмжийн үнэлгээг төхөөрөмжөөр, Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын үйл ажиллагаатай холбоотой үнэлгээг угтах хэсэгт байршуулах гомдол, санал, талархал авах хайрцагаар тус тус хүлээн авна.

3.8. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын Сонирхлын бүлгүүдийн үйл ажиллагааг эхлүүлж, идэвхжүүлэх арга хэмжээг авна.

3.9. Албан хаагчдын дунд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Coffee time” өглөөний уулзалтыг зохион байгуулна.

3.10. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдах албан тушаалтан, Хүний нөөцийн асуудал хариуцсан албан хаагчдын дунд “HR-2023” арга хэмжээг зохион байгуулна.

II. Хэлтсүүд аянд дараах байдлаар оролцоно. Үүнд:

3.11. Төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээг таниулж, мөрдүүлэх чиглэлээр соён гэгээрүүлэх, ухуулах, таниулах арга хэмжээг санаачлан зохион байгуулна.

3.12. Албан хаагчдын багаар ажиллах чадварыг сайжруулах хүрээнд албан хаагч бүрийн оролцоог хангасан арга хэмжээ зохион байгуулна. Энэхүү арга хэмжээ нь нийтийг хамарсан, ажлын байранд зохиогдох боломжтой байх бөгөөд мэдээллийг албан хаагчдад урьдчилан хүргэнэ.

3.13. Өөрсдийн боломжид тулгуурлан ажлын байрыг эмх цэгцтэй болгох, шинэлэг орчин бүрдүүлэх чиглэлээр санаачилгатай ажилласан байна.

3.14. Албан хаагчид өдөр тутмын үйл ажиллагаандаа дараах нийтлэг хэм хэмжээг хэвшүүлсэн байна. Үүнд:

- ✓ Ажлын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг сайжруулах;
- ✓ Харилцааны эерэг соёлыг нэмэгдүүлэх, хандлагыг дээшлүүлэх;
- ✓ Ажил хэрэгч хувцаслалтыг хэвшүүлэх.

Дөрөв.Үр дүн

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын Авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаарх мэдлэг дээшилж, байгууллагын Хөдөлмөрийн дотоод журам, Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилт хангагдсан байна.

Тав. Аяны үр дүнг үнэлэх, урамшуулах

5.1. Хэлтэс, нэгжүүд 2023 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн дотор аяны хүрээнд хийсэн ажлын тайланг Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Хүний нөөцийн удирдлагын тасагт ирүүлнэ.

5.2. Үр дүнг Тамгын газрын удирдлагын баг үнэлнэ.

5.3. Аянд идэвх санаачилгатай оролцож, тодорхой үр дүнд хүрсэн хэлтэс, нэгжээс 1-3 дугаар байрыг шалгаруулан, мөнгөн урамшуулал олгоно.